

ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ
ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠤᠳᠢᠲᠤ ᠭᠠᠰᠠᠷ

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



АЙМГИЙН 2023 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

2024 он



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/09

Есөнбулаг

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.1, 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Говь-Алтай аймгийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан”-г нэгдүгээр хавсралтаар, аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад хүргүүлсүгэй.

3. Аудитаар хүргүүлсэн албан шаардлага, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (О.Амгаланбаатар), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Х.Баатарзориг), Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга (Ж.Төгөлдөр) нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитын үр дүнд хяналт тавьж, хэрэгжилтийг тайлагнахыг аудитын менежер (Д.Эрдэнэчимэг)-т даалгасугай.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Д.Цэрэнханд)-д үүрэг болгосугай.



Т.ГҮНЖИДМАА

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудиторын
2024 оны 07 дүгээр сарын 20-ны
өдрийн 4/09 дугаар тушаалын хавсралт

Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

д/д	Хариуцагч	Шийдвэрийн			Зөрчлийн утга	Зөрчлийн дүн /сая төгрөг/
		Төрөл	Огноо	Дугаар		
1	Аймгийн Засаг дарга	Албан шаардлага	2024.04.22	03/187	Харьяа байгууллагуудын удирдлагын буруутай шийдвэрээс болж ажлаас халагдсан ажилтанд төсвөөс нөхөн олговор олгосон.	109.1
2	Аймгийн Засаг дарга	Албан шаардлага	2024.04.22	04/187	Хантайшир Уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ойд төсвөөс хөрөнгө зарцуулсан.	58.7

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН 2023 ОНЫ НЭГДСЭН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН**

Алтай хот
2024 он

Тайлан бэлтгэсэн:	АГУУЛГА	
Дарга, Тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа	ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	4
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг	ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	5
Ахлах аудитор: Д.Цэрэнханд	I БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ	6
Аудитор: Н.Гэрэлмаа С.Санчирмаа	1.1 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт	6
	1.2 Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл.....	6
	II БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ	9
	2.1 Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөлт	9
	2.2 Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл	9
	2.3 Орон нутгийн хөгжлийн сан.....	11
	2.4 Хоршоо хөгжүүлэх сан	11
	III БҮЛЭГ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ	12
	4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
	4.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	12
	4.3 Бусад хууль тогтоомжийн хүрэн дэх нийцлийн аудитын асуудал13	
2024 оны 04 дүгээр сар	IV БҮЛЭГ. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	14
Уг тайланг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын цахим хуудаснаас үзнэ үү: www.audit.mn	V БҮЛЭГ. ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛ, ДҮГНЭЛТ	15
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70483413 дугаар утсаар харилцана уу.	VI АУДИТЫН ДҮГНЭЛТ	15
ХАЯГ: Говь-Алтай аймаг Есөнбулаг сум Жинст баг Хөгжил хороолол 1402	6.1 Үндэсний аудитын газарт хүргүүлэх санал.....	16
	6.2 Аудитын зөвлөмж	16

Товчилсон үгийн жагсаалт

1	ААН	Аж ахуйн нэгж
2	ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
3	ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
4	АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
5	АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
6	БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
7	ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
8	ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
9	ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
10	ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
11	ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
12	ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
13	ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
14	ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
15	УИХ	Улсын Их Хурал
16	УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
17	УЦС	Усан цахилгаан станц
18	ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
19	ХХС	Хоршоо хөгжүүлэх сан

Хүснэгтийн тайлбар

Хүснэгт 1	Орон нутгийн 2023 оны төсвийн орлогын төлөвлөлт
Хүснэгт 2	Орон нутгийн 2023 оны төсвийн орлого
Хүснэгт 3	Орон нутгийн 2023 оны нийт орлого /сумдаар/
Хүснэгт 4	Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн
Хүснэгт 5	Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн /сумдаар/
Хүснэгт 6	Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт
Хүснэгт 7	ОНХС-ийн орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт 8	Сумдын ХХС-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл
Хүснэгт 9	Төсвийн санал, хэрэгжилт
Хүснэгт 10	Төсвийн гүйцэтгэлийн тайлан

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1¹-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4² дахь заалтын дагуу Говь-Алтай аймгийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийв.

Аудитын зорилт

Орон нутгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын хамарсан хүрээ

Говь-Алтай аймгийн 2023 оны төсвийн гүйцэтгэлд дараах бүрэлдэхүүнээр аудит хийлээ. Үүнд:

- Орон нутгийн 2023 оны төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл
- Орон нутгийн 2023 оны төсвийн зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл
- Нэмэлт төсвийн 2023 оны гүйцэтгэлийн тайлан
- Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- Төсвийн төсөлд өгсөн санал дүгнэлт

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 3000, Аудитын олон улсын стандарт, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмыг баримтлан аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн болон бусад холбогдох хэлтэс, сумдын төсөвт байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа, тоон мэдээлэл авах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсрууллаа.

Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Цэрэнханд, аудитор Н.Гэрэлмаа, С.Санчирмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа хэрэгжүүлсэн.

¹ 8.1. Төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуульд заасны дагуу улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн байгууллага, төсөв захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн санхүүгийн тайланд аудит хийнэ.

² 8.9.4.аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ



Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг хангуулахаар ажилласан байна.

Төрийн аудитын газраас Говь-Алтай аймгийн 2023 оны төсвийн төсөлд тусгагдсан татварын болон татварын бус орлогыг 1,404.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх, суурь зарлагыг 7,445.5 сая төгрөгөөр бууруулах, нийт 8,850.4 сая төгрөгийн саналыг хүргүүлсэн.

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд аймгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 18,485.8 сая төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймагт олгох орлогын шилжүүлгийг 15,122.9 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Говь-Алтай аймгийн 2023 оны татварын ба татварын бус орлого, улсын төсвийн санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг, төсвийн байгууллагын өөрийн орлогоос бүрдэх эх үүсвэрийг нийт 63,492.9 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 56,181.5 сая төгрөг зарцуулжээ.

Говь-Алтай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 64 дүгээр тогтоолоор төсвийн нийт орлого, тусламжийн дүнг 54,249.0 сая төгрөгөөр тодотгон баталсан бөгөөд 102.0 хувь буюу 55,077.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарчээ.

Тайлант оны төсвийн орлогын гүйцэтгэл 84.3 хувь, зарлагын гүйцэтгэл 84.9 хувьтай байна. Аймгийн 2023 оны төсвийн саналыг онлайн суурилсан FISCAL-B системээр Сангийн яаманд хүргүүлсэн байна.

I БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ**1.1 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт**

Аймгийн 2023 оны төсвийг Төсвийн тухай хуулийн 57 дугаар зүйл, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах" журам, аймгийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, холбогдох бусад хууль эрхзүйн актуудыг үндэслэн төлөвлөж, төсвийн төслийн саналыг FISCAL-B системд оруулснаар Сангийн яам хянаж, баталгаажуулсан байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны Төсвийн төсөөллийн тухай хуульд нийцүүлэн орон нутгийн төсвийн суурь орлогыг урьдчилсан байдлаар 2022 оны түвшинд тооцож, суурь орлогыг 10,350.7 сая төгрөгөөр хянасныг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 64 дүгээр тогтоолоор зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг анх 20,082.6 сая төгрөг болгож баталсан байна.

Хүснэгт 1. Орон нутгийн 2023 оны төсвийн орлогын төлөвлөлт /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Сангийн яамны хянасан дүн	2023 он		Анх батлагдсан дүнгээс өссөн/буурсан
			Анх баталсан	Тодотгосон төсөв	
1	Орон нутгийн төсвийн суурь орлого	10,350.7	20,082.6	24,678.4	4,595.8
2	Нийт орлого ба тусламжийн дүн	10,350.7	20,082.6	24,678.4	4,595.8

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Орон нутгийн орлогын 2023 оны төсвийн төлөвлөгөө өмнөх оны гүйцэтгэлээс 13,281.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

1.2 Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл

Орон нутгийн төсвийн орлогыг 54,249.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс 1.5 хувиар буюу 828.6 сая төгрөгөөр илүү төвлөрүүлсэн нь өмнөх оны гүйцэтгэлээс 14,108.7 сая төгрөгөөр өссөн байна. Нийт орлогын 30.3 хувийг татварын, 69.7 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Хүснэгт 2. Орон нутгийн 2023 оны төсвийн орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	2022 он	2023 он			
	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Нийт орлого ба тусламжийн дүн	40,968.9	54,249.0	55,077.6	102.0	(828.6)
Татварын орлого	11,607.6	15,074.5	16,662.0	111.0	(1,587.5)
Орлогын албан татвар	8,149.2	10,849.3	12,115.30	112.0	(1,266.0)
Хөрөнгийн албан татвар	1,856.9	2,200.8	2,520.80	115.0	(320.0)
ААНОАТ	80.6	250.0	306.8	123.0	(56.8)
Бусад татвар төлбөр хураамж	1,601.5	2,024.4	2,025.90	100.0	(1.5)
Татварын бус орлого	29,280.7	39,174.5	38,415.6	98.0	758.9
Нийтлэг бус татварын орлого	1,587.1	5,565.9	3,419.80	61.0	2,146.1
Хөрөнгийн орлого	1,203.5	-	1,673.30		(1,673.3)
Тусламжийн орлого	1,510.9	-			-
ОНХС-ийн нэгдсэн сангаас	9,878.5	15,122.8	14,863.70	98.0	259.1
Тусламж/ Шилжүүлэг	15,103.7	18,485.8	18,458.80	100.0	27.0

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Говь-Алтай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 64 дүгээр тогтоолоор төсвийн нийт орлого, тусламжийн дүнг 54,249.0 сая төгрөгөөр тодотгон баталсан бөгөөд 102.0 хувь буюу 55,077.6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарчээ.

Орон нутгийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 828.6 сая төгрөгөөр давж биелсэн боловч 8 нэр төрлийн орлого 3,714.3 сая төгрөгөөр тасарч, төлөвлөгдөөгүй орлого ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 0.3 сая төгрөг, бусад татвар 4.3 сая төгрөг, өмч хувьчлалын орлого 1,673.3 сая төгрөг төвлөрсөн байна.

Илрүүлэлт:

Торгуулийн орлого 1,861.0 сая төгрөг, хүүгийн орлого 779.8 сая төгрөг, малын тоо толгойн албан татварын орлого 405.2 сая төгрөг, бусад орлого 345.8 сая төгрөг, дуудлага худалдааны орлого 283.2 сая төгрөг, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар 31.9 сая төгрөг, түрээсийн орлого 5.3 сая төгрөг, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 2.1 сая төгрөгөөр тус тус тасарсан.

Давсан орлогын талаар:

- Хувь хүний орлогын албан татварын орлого 1,063.4 сая төгрөгөөр давсан нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 488, 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн баталсан, Тайшир Гуулин УЦС ХХК, Алтайн хүдэр ХХК-иас татварын өр 585.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн;
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого 753.5 сая төгрөгөөр давсан нь Тайшир Гуулин УЦС ХХК, Алтайн хүдэр ХХК-аас татварын өр 632.3 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн, хувь хэмжээг шинэчлэн баталсантай холбоотойгоор эмийн сан, шатахуун түгээх станцуудаас орлого төвлөрүүлсэн;
- Ан амьтны нөөц ашигласны төлбөр 116.7 сая төгрөгөөр давсан нь ан амьтан агнах зөвшөөрөлтэй уялдуулан тодотгож батлаагүй;
- Ус рашааны нөөц ашигласны төлбөр 71.3 сая төгрөгөөр давсан нь Хан-Алтай ресурс ХХК-аас үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны төлбөрийг төвлөрүүлсэн;
- Газрын төлбөрийн орлого 68.4 сая төгрөгөөр давсан нь Алтай хүдэр ХХК, Тайшир Гуулин УЦС ХХК-ий газрын төлбөрийн өглөгийг барагдуулсан;
- Шууд бус орлого 62.7 сая төгрөгөөр давсан нь арьс шир, ноосны урамшууллаас татвар суутгаж төвлөрүүлсэн;
- Аж ахуй нэгжийн орлогын албан татвар 56.8 сая төгрөгөөр давсан нь төлөвлөлтийг бодитой бус тооцсон;
- Хөрөнгийн орлого 49.1 сая төгрөгөөр давсан нь банкны хадгаламжийн хүү өссөн;
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 13.1 сая төгрөгөөр давсан нь гудамж, талбайн тохижилт, авто зам, явган хүний зам шинээр барихад ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөцийн төлбөрийг төсөвт төвлөрүүлсэн;
- Улсын тэмдэгтийн хураамж 11.2 сая төгрөгөөр давсан нь өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулан төлөвлөлтийг бодитой бус тооцсон;
- Хөрөнгө борлуулсны орлого 10.5 сая төгрөгөөр давсан нь шинээр ашиглалтад орсон нийтийн орон сууцны борлуулалт нэмэгдсэн;
- Үйл ажиллагааны орлого 6.9 сая төгрөгөөр давсан нь төрийн сангийн удирдлагын цахим систем нэвтрэлтийн нэгдсэн цахим системтэй холбогдсоноор татварын ногдуулалт нэмэгдсэн;
- Галт зэвсгийн албан татвар 3.6 сая төгрөгөөр давсан нь галт зэвсгийн бүртгэл, хөдөлгөөний мэдээллийг тулган баталгаажуулж, иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа 28 галт зэвсгийг бүртгэсэн;

Тасарсан орлогын талаар:

- Хүү, торгуулийн орлого 2,640.0 сая төгрөгөөр тасарсан нь бодитой төлөвлөөгүй;
- Малын тоо толгойн албан татвар 405.2 сая төгрөгөөр тасарсан нь малчдыг мэдээллээр хангаагүй, татварыг төвлөрүүлэх ажлыг хангалтгүй зохион байгуулсан;
- Бусад орлого 343.2 сая төгрөгөөр тасарсан нь УИХ-ын гишүүний багцаас олгосон зээлийн эргэн төлөлт хангалтгүй;
- Газрын дуудлага худалдааны орлого 283.2 сая төгрөгөөр тасарсан нь газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг оны эцэст баталсан;
- Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар 31.9 сая төгрөгөөр тасарсан нь аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй уул уурхайн компаниудын авто тээврийн хэрэгслүүдээс орлого төвлөрүүлэхээр тооцсон боловч тухайн хуулийн этгээдийн авто тээврийн хэрэгсэл нь аймагт бүртгэлгүй;

- Түрээсийн орлого 5.3 сая төгрөгөөр тасарсан нь түрээсийн орлогын 40 хувийг орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлээгүй;
- Хог хаягдлын үйлчилгээний хураамж 2.1 сая төгрөгөөр тасарсан нь албан татварыг төвлөрүүлэх ажлыг хангалтгүй зохион байгуулснаас шалтгаалжээ.

Орон нутгийн нийт орлого 828.6 сая төгрөгөөр давж биелсэн боловч аймаг, Бигэр, Дарив, Халиун, Хөхморьт, Цээл, Шарга сумдын орлого 473.7 сая төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт 3. Орон нутгийн 2023 оны нийт орлого /сумдаар/ /сая төгрөг/

Сум, байгууллага	Орлого				Сум, байгууллага	Орлого			
	Төл	Гүйц	Хувь	Зөрүү		Төл	Гүйц	Хувь	Зөрүү
Алтай	1,152.6	1,403.3	121.7	(250.7)	Хөхморьт	671.9	632.3	94.1	69.6
Баян-Уул	574.5	608.9	106.0	(34.4)	Цогт	940.8	1,011.1	107.5	(70.3)
Бигэр	677.4	643.1	94.9	34.3	Цээл	997.4	802.2	80.4	195.2
Бугат	544.1	628.3	115.5	(84.2)	Чандмань	731.5	767.2	104.9	(35.7)
Дарив	477.9	474.3	99.2	3.6	Шарга	596.8	528.3	88.5	68.5
Дэлгэр	584.6	617.7	105.7	(33.1)	Эрдэнэ	972.0	1,001.6	103.0	(29.6)
Жаргалан	385.4	453.1	117.6	(67.7)	Гуулин тосгон	113.2	124.5	101.9	(11.3)
Тайшир	569.8	612.3	107.5	(42.5)	Баянтоорой тосгон	135.6	151.1	111.4	(15.5)
Тонхил	650.5	726.5	111.7	(76.0)	Есөнбулаг	9,832.6	10,276.4	104.5	(443.8)
Төгрөг	507.5	585.5	115.4	(78.0)	Аймаг	32,579.2	32,511.0	99.8	68.2
Халиун	553.3	519.0	93.8	34.3					
Нийт дүн						55,249.0	55,077.6	101.5	828.6

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тусламж санхүүжилтийн орлого

Тайлант онд төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 39,020.9 сая төгрөг, ОНХС-ийн орлогын шилжүүлэг 14,863.7 сая төгрөг, төсвийн байгууллагын үйл ажиллагааны орлого 1,729.4 сая төгрөг, нийт 55,614.1 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Илрүүлэлт:

- Орлогын төлөвлөгөө нэр төрлөөр 4,527.3 сая төгрөгөөр тасарсан /Аймгийн ТЕЗ-3,714.3 сая төгрөг, Цээл сум-122.2 сая төгрөг, Халиун сум-114.3 сая төгрөг, Хөхморьт сум-89.9 сая төгрөг, Бигэр сум-55.9 сая төгрөг, Цогт сум-50.9 сая төгрөг, Тайшир сум-44.4 сая төгрөг, Солонго дулааны станц 48.7 сая төгрөг, Дарив сум-43.5 сая төгрөг, Тонхил сум-39.4 сая төгрөг, Чандмань сум-39.0 сая төгрөг, Гуулин тосгон-35.4 сая төгрөг, Бугат сум-24.5 сая төгрөг, Эрдэнэ сум-19.2 сая төгрөг, Чандмань сум-15.4 сая төгрөг, Дэлгэр сумын ХХС-12.9 сая төгрөг, Алтай сум-10.5 сая төгрөг, Эрдэнэ сумын ХХС-10.0 сая төгрөг, Халиун сумын ХХС-8.6 сая, Есөнбулаг сум- 7.0 сая төгрөг, Баянтоорой тосгон-6.4 сая төгрөг, Бигэр сумын ХХС-4.3 сая төгрөг, Нийтлэг үйлчилгээ УТҮГ-4.3 сая төгрөг, Шарга сум-1.7 сая төгрөг, Шарга сумын ЗДТГ-1.5 сая төгрөг, Гуулин тосгон-1.5 сая төгрөг, Төгрөг сум-1.4 сая төгрөг/;
- Төлөвлөлтөйг бодитой төлөвлөөгүйгээс 3.7 сая төгрөг /Цогт сум-1.8 сая төгрөг, Халиун сум-1.3 сая төгрөг, Чандмань сум-0.6 сая төгрөг/;
- Малын тоо толгойн албан татварын орлого 237.6 сая төгрөгөөр тасарсан /Дэлгэр сум-66.6 сая төгрөг, Тонхил сум-59.4 сая төгрөг, Есөнбулаг сум-29.4 сая төгрөг, Бугат сум-28.9 сая төгрөг, Баян-Уул сум-28.8 сая төгрөг, Халиун сум-14.7 сая төгрөг, Цогт сум-6.7 сая төгрөг, Гуулин тосгон-1.8 сая төгрөг, Эрдэнэ сум-1.3 сая төгрөг/.

II БҮЛЭГ. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөлт**

Сангийн яамнаас орон нутгийн төсвийн суурь зарлагын дүнг 33,047.8 сая төгрөгөөр хянасан бөгөөд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас анх 55,691.6 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн төсөвт нийт 4 удаагийн тодотголыг хийж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 64 дүгээр тогтоолоор орон нутгийн төсвийн суурь зардлыг 63,492.9 сая төгрөг буюу 7,801.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

2.2 Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл

Тайлант оны орон нутгийн төсвийн нийт зарлага 56,171.5 сая төгрөг буюу 88.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 4. Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн

/сая төгрөг/

Үзүүлэлт	2022 он гүйцэтгэл	2023 он			
		Төлөвлөлт	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	44,508.1	63,492.9	56,171.5	88.0	7,321.4
А. Урсгал зардал	26,457.7	40,149.6	37,710.1	94.0	2,439.5
Бараа, ажил үйлчилгээний зардал	24,749.5	38,888.3	36,532.1	94.0	2,356.2
Хүү	-	-	-	-	-
Татаас	100.0	-	-	-	-
Урсгал шилжүүлэг	1,608.3	1,261.3	1,178.0	93.0	83.3
Б. Хөрөнгийн зардал	16,861.1	21,493.2	17,360.9	81.0	4,132.2
В. Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	1,189.3	1,850.1	1,100.5	59.0	749.6

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн 70.0 хувийг урсгал зардал, 28.0 хувийг хөрөнгийн зардал, 2.0 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээл эзэлж байна.

Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 88.8 сая төгрөгөөр тус буурч, хөрөнгийн зардал өмнөх оноос 509.8 сая төгрөгөөр, урсгал зардал 11,252.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, нийт зардал 21.1 хувиар өссөн байна. Энэ нь төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Удирдлагын буруутай шийдвэрээр ажлаас халагдсан ажилтнуудад 109.1 сая төгрөгийн цалингийн нөхөн олговрыг олгож, буруутай этгээдээс нэхэмжлээгүй байгууллагын төсөв хохироосон байна.

Хүснэгт 5. Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн /сумдаар/

/сая төгрөг/

Сум, байгууллага	Зарлага				Сум, байгууллага	Зарлага			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Алтай	1,696.3	1,362.9	80.3	333.4	Хөхморьт	1,453.9	1,178.3	81.0	275.6
Баян-Уул	2,008.7	95.5	97.8	2.2	Цогт	2,103.7	1,926.0	91.5	177.7
Бигэр	1,371.5	1,098.0	80.0	273.5	Цээл	1,713.1	1,289.7	75.2	423.3
Бугат	1,489.6	1,147.8	77.0	341.8	Чандмань	1,747.1	1,472.9	84.3	274.2
Дарви	1,411.4	1,222.1	86.6	189.3	Шарга	1,636.5	1,426.3	87.2	210.2
Дэлгэр	1,525.7	1,259.2	82.5	266.5	Эрдэнэ	2,088.8	1,852.3	88.7	236.5
Жаргалан	1,591.6	1,321.1	83.0	270.6	Гуулин тосгон	279.5	273.0	97.7	6.5
Тайшир	1,532.6	1,349.3	88.0	183.3	Баянтоорой тосгон	324.0	308.5	95.2	15.5
Тонхил	1,801.3	1,524.3	84.5	277.0	Есөнбулаг	9,937.6	9,759.2	98.3	168.4
Төгрөг	1,386.8	1,197.7	86.4	189.2	Аймгийн шууд	24,881.3	22,132.0	93.0	9.0
Халиун	1,510.4	1,291.9	85.5	218.5					
						63,492.9	56,171.5	88.0	7,311.4

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хүснэгт 6. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт /сая төгрөг/

№	Хөтөлбөр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	70105 Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	3,347.6	3,146.5	201.1
2	70106 Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	24,155.4	20,316.7	3,838.7
3	70417 Мэргэжлийн хяналт	235.0	220.5	14.4
4	70426 Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	349.3	314.3	35.0
5	70503 Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	19,669.8	18,568.3	1,101.5
6	70801 Мал аж ахуйг хөгжүүлэх	251.6	190.0	61.6
7	70802 Газар тариалан хөгжүүлэх	50.0	6.7	43.3
8	71403 Ойжуулалт	186.0	168.3	17.7
9	71411 Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	1,225.3	1,172.3	53.0
10	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	669.5	597.8	71.7
11	71701 Биеийн тамир спорт	348.2	347.6	0.6
12	71702 Соёл урлаг	1,899.0	1,679.5	219.5
13	71801 Сургуулийн өмнөх боловсрол	1,661.9	1,505.5	156.4
14	71802 Ерөнхий боловсрол	6,386.6	6,100.9	285.6
15	71804 Мэргэжлийн боловсрол	574.8	574.8	-
16	71806 Насан туршийн болон албан бус боловсрол	18.0	18.0	-
17	71902 Нийгмийн халамж	130.0	102.5	27.5
18	72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	2,334.9	1,141.3	1,193.6
	Дүн	63,492.9	56,171.5	7,321.4

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн гүйцэтгэлтэй холбоотой 4,312.0 сая төгрөгийн 94 зөрчил илэрснээс 0.7 сая төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,957.4 сая төгрөгийн зөрчилд 87 албан албан шаардлага, 2,353.9 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн.

Илрүүлэлт:

- Харьяа байгууллагууд 787.3 сая төгрөгийн төсвийг үр ашиггүй зарцуулсан /Аймгийн ЗДТГ-390.5 сая төгрөг, ТЕЗ-293.5 сая төгрөг, Тонхил сумын ЗДТГ-26.3 сая төгрөг, Орон нутгийн Алтай радио-25.7 сая төгрөг, Шарга сумын ЗДТГ-19.9 сая төгрөг, Тонхил сумын ИТХ-19.0 сая төгрөг, Ахмадын хороо-8.5 сая төгрөг, Дарив сумын ЗДТГ-3.8 сая төгрөг/;
- Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж 60.2 сая төгрөгийн гүйлгээг хийсэн /Есөнбулаг сумын ЗДТГ-15.9 сая төгрөг, Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв УТҮГ-10.5 сая төгрөг, аймгийн ЗДТГ-9.4 сая төгрөг, Есөнбулаг сумын-ИТХ 7.6 сая төгрөг, Гуулин тосгоны захирагчийн ажлын алба-4.0 сая төгрөг, Нийтийн номын сан-3.3 сая төгрөг, Шарга сумын ЗДТГ-2.5 сая төгрөг, Дарив сумын ЗДТГ-2.2 сая төгрөг, Бигэр сумын ИТХ-1.7 сая төгрөг, Цээл сумын ИТХ-1.2 сая төгрөг, Баян-Уул сумын ЗДТГ-1.1 сая төгрөг, Дарив сумын ИТХ-0.3 сая төгрөг, Дэлгэр сумын ИТХ-0.3 сая төгрөг/;
- Мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй компаниар гэрэлтүүлгийн урсгал засвар үйлчилгээ хийлгэж 54.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон.
- Нийтлэг үйлчилгээ УТҮГ нь батлагдсан төлөвлөгөөнөөс 33.5 сая төгрөгийн зардлыг илүү зарцуулсан;
- Есөнбулаг сумын ЗДТГ нь 13.9 сая төгрөгийн тэтгэмжийг илүү, дутуу тооцож олгосон;
- Байгууллагын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түшингийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан эрх бүхий байгууллагаар шинэчлэн батлуулаагүй /Алтай хотын тохижилт үйлчилгээний газар, Ундарга-Алтай ААТҮГ, Инноваци судалгаа бизнес хөгжлийн төв УТҮГ, Нийтлэг үйлчилгээ УТҮГ/;
- Төсвөөс 0.6 сая төгрөгийн торгууль, ажлын төлбөрийг төлсөн /Ахмадын хороо-0.3 сая төгрөг, Есөнбулаг сумын ЗДТГ-0.2 сая төгрөг, Нийтийн номын сан-0.06 сая төгрөг/;
- Ажилтанд ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй, нөхөн олговрыг тооцож олгоогүй /Ахмадын хороо/;
- Бугат сумын ЗДТГ нь түрээсийн гэрээ байгуулсан боловч гэрээний дагуу 0.1 сая төгрөгийн түрээсийг төвлөрүүлээгүй;

2.3 Орон нутгийн хөгжлийн сан

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 15,122.9 сая төгрөгөөр баталсан боловч гүйцэтгэлээр 14,863.8 сая төгрөгийг санхүүжүүлж, 259.1 сая төгрөгийг дутуу олгожээ. Нийт санхүүжилтээс сумдад 6,602.3 сая төгрөгийг олгосон байна.

Хүснэгт 7. ОНХС-ийн орлогын шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөг/

Сумын нэр	ОНХС-ийн орлого			Сумын нэр	ОНХС-ийн орлого		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Алтай	480.2	465.9	97.0	Хөхморьт	270.1	262.0	97.0
Баян-Уул	221.1	214.4	97.0	Цогт	520.2	504.6	97.0
Бигэр	241.0	233.7	97.0	Цээл	277.1	268.8	97.0
Бугат	155.9	151.2	97.0	Чандмань	350.1	339.6	97.0
Дарви	126.5	122.7	97.0	Шарга	180.4	174.9	97.0
Дэлгэр	200.9	194.8	97.0	Эрдэнэ	606.5	588.3	97.0
Жаргалан	140.8	136.5	96.9	Есөнбулаг	2,166.7	2,101.7	97.0
Тайшир	200.7	194.7	97.0	Аймаг	8,316.1	8,261.2	99.3
Тонхил	298.7	289.7	97.0				
Төгрөг	160.2	155.3	96.9				
Халиун	209.7	203.5	97.0				
Нийт дүн					15,122.9	14,863.5	98.3

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аймгийн ОНХС-аас нийт 9,107.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хөрөнгийн зардалд 23.5 хувь буюу 2,140.5 сая төгрөг, хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд 74.1 хувь буюу 6,752.0 /боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрт 1,882.9 сая төгрөг, газар тариалан, жимс жимсгэнэ хөтөлбөрт 883.1 сая төгрөг, сумдын шинэчлэл, хөдөөгийн хөгжил хөтөлбөрт 1,303.2 сая төгрөг, эрүүл мэндийн салбарын албан хаагчдыг орон сууцаар хангах, дэмжлэг үзүүлэх хөтөлбөрт 800.0 сая төгрөг/, бусад урсгал зардал, баяр наадмын зардалд 2.4 хувь буюу 214.5 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгийн 50.1 хувийг хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлэх зардалд төлөвлөж, зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.7.6-д "Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал" заалттай нийцэхгүй байна.

2.4 Хоршоо хөгжүүлэх сан

Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг 961.2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,005.5 сая төгрөгийн зээл төлөгдсөн байна.

Хүснэгтээс харахад 13 сум төлөвлөсөн орлогоо бүрэн төвлөрүүлж, 5 сум дутуу төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 8. Сумдын ХХС-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөг/

Сумын нэр	ХХС-ийн орлого			Сумын нэр	ХХС-ийн орлого		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Алтай	32.2	61.5	191.0	Хөхморьт	37.5	40.4	107.7
Баян-Уул	30.0	49.0	163.3	Цогт	100.0	49.1	49.1
Бигэр	73.5	69.7	94.8	Цээл	0.6	5.9	983.3
Бугат	15.0	19.9	132.7	Чандмань	33.8	24.1	71.3
Дарви	0.8	24.1	3012.5	Шарга	42.0	54.4	129.5
Дэлгэр	123.1	45.6	37.0	Эрдэнэ	48.2	37.2	77.2
Жаргалан	46.1	55.3	120.0	Есөнбулаг	201.0	211.6	105.3
Тайшир	51.1	80.8	158.3				
Тонхил	40.6	71.9	177.1				
Төгрөг	40.0	56.9	142.3				
Халиун	45.7	48.1	105.3				
Нийт дүн					961.2	1,005.5	104.6

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Сумдын Хоршоо хөгжүүлэх сангийн санхүүгийн тайлангийн аудитаар 164.4 сая төгрөгийн үндсэн зээл, 6.9 сая төгрөгийн хүүгийн төлбөрийг зээлийн гэрээнд заасан хугацаанд төлөөгүйд төлбөрийн акт тогтоож, зээлийн гэрээний хугацаа дууссан боловч арга хэмжээ авч ажиллаагүй 6.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.

Илрүүлэлт:

- Нийт 164.4 сая төгрөгийн үндсэн зээлийг төлөөгүй /Цогт сум-25.7 сая төгрөг, Хөхморьт сум-25.4 сая төгрөг, Халиун сум-23.6 сая төгрөг, Дэлгэр сум-18.1 сая төгрөг, Шарга сум-15.9 сая төгрөг, Есөнбулаг сум-10.6 сая төгрөг, Алтай сум-9.7 сая төгрөг, Бигэр сум-8.7 сая төгрөг, Эрдэнэ сум-6.3 сая төгрөг, Төгрөг сум-4.5 сая төгрөг, Баян-Уул сум-4.3 сая төгрөг, Тонхил сум-4.3 сая төгрөг, Чандмань сум-3.3 сая төгрөг, Бугат сум-2.3 сая төгрөг, Тайшир сум-1.5 сая төгрөг, Дарив сум-0.2 сая төгрөг/;
- Нийт 6.9 сая төгрөгийн зээлийн хүүг хугацаанд нь төлөөгүй /Цогт сум-3.6 сая төгрөг, Есөнбулаг сум-0.7 сая төгрөг, Алтай сум-0.5 сая төгрөг, Халиун сум-0.6 сая төгрөг, Шарга сум-0.5 сая төгрөг, Хөхморьт сум-0.5 сая төгрөг, Чандмань сум-0.4 сая төгрөг, Эрдэнэ сум-0.06 сая төгрөг, Тайшир сум-0.04 сая төгрөг/;
- Жаргалан сумын ХХС-ийн төсвийн хэлбэлзэл 2.0 сая төгрөгөөр зөрүүтэй;
- Зээлийн гэрээний хугацаа дууссан зээлийг төлүүлэх талаар хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлээгүй, арга хэмжээ аваагүй 6.0 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй /Эрдэнэ сумын ХХС-4.9 сая төгрөг, Бигэр сумын ХХС-1.1 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй;
- Зээлийн гэрээний хугацаа дууссан боловч зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчид шинээр 12.0 сая төгрөгийн зээл олгосон /Дэлгэр сумын ХХС/.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон төлбөрийн актын үлдэгдэл хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 994.2 сая төгрөгийг төлүүлээгүй байна. Энэ нь эх үүсвэр дутагдах, зээлийн эргэлтийг удаашруулах эрсдэлийг үүсгэж байна.

III БҮЛЭГ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

Холбогдох хууль, тогтоомжийг зөрчсөн нийцлийн асуудлаар нийт 2,250.3 сая төгрөгийн 87 зөрчил илэрснээс 6.4 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,930.7 сая төгрөгийн зөрчилд 78 албан албан шаардлага, 313.9 сая төгрөгийн 8 зөвлөмж хүргүүлсэн.

4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих тендерт шалгарсан оролцогчийн 6,315.4 сая төгрөгийн 79 мэдээллийг бүрэн мэдээлж, төсөв өмч хөрөнгө зарцуулсан 11,322.7 сая төгрөгийн 349 тушаалаас 103.0 сая төгрөгийн 33 мэдээллийг байршуулаагүй бөгөөд хэрэгжилт 98.7 хувьтай байна.

Шилэн дансанд 103.0 сая төгрөгийн 33 мэдээллийг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-6.10-д заасан "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд зөвлөмж хүргүүлээ.

Илрүүлэлт

- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй, дутуу хөтөлсөн 19 байгууллага /Бигэр сумын ЗДТГ, ХХС, Дарив сумын ХХС, Жаргалан сумын ЗДТГ, ИТХ, Тайшир сумын ЗДТГ, ХХС, Чандмань сумын ТТЗ, Эрдэнэ сумын ХХС, Гуулин тосгоны ТТЗ, Захирагчийн ажлын алба, Есөнбулаг сумын ЗДТГ, ИТХ, Марал-Алтай ӨЭМТ, Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ, Ундарга-Алтай ААТҮГ, Ахмадын хороо гэсэн байгууллагуудад зөрчил арилгах албан шаардлага, аймгийн ЗДТГ, БОАЖГ-т зөвлөмж тус тус хүргүүлсэн байна/.

4.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Монгол Улсын Их Хурлаас төр, бүх шатны байгууллага, нийтийн алба тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баталж мөрдүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн 607.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 606.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

Илрүүлэлт:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаагүй 607.8 сая төгрөг (Аймгийн ЗДТГ-481.4 сая төгрөг, Есөнбулаг сумын ЗДТГ-36.4 сая төгрөг, Халиун сумын ЗДТГ-18.8 сая төгрөг, Хөхморьт сумын ЗДТГ-15.0 сая төгрөг, Эрдэнэ сумын ЗДТГ-11.9 сая төгрөг, Цогт сумын ЗДТГ-8.1 сая төгрөг, Эрдэнэ сумын ИТХ-8.0 сая төгрөг, Алтай сумын ЗДТГ-7.3 сая төгрөг, Чандмань сумын ЗДТГ-6.3 сая төгрөг, Баян-Уул сумын ЗДТГ-5.1 сая төгрөг, Дэлгэр сумын ЗДТГ-4.0 сая төгрөг, Тайшир сумын ЗДТГ-3.6 сая төгрөг, Ундарга-Алтай ААТҮГ-1.0 сая төгрөг, Ахмадын хороо-1.0 сая төгрөг)

Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ыг баталсан. Уг журмын 2.1.4, 2.1.5, 2.1.6 заалтуудын дагуу аймаг, сумдын Засаг даргын нөөц хөрөнгөөс 607.8 сая төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3 дахь заалттай нийцэхгүй байна.

4.3 Бусад хууль тогтоомжийн хүрэн дэх нийцлийн аудитын асуудал:

Төсвийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, байгууллагын дотоод журамтай нийцэж байгаа эсэх асуудлыг энэ хүрээнд хамруулсан.

Илрүүлэлт

- Тендер, худалдан авах ажиллагаа зарлаагүй 732.4 сая төгрөг /Аймгийн ЗДТГ-262.1 сая төгрөг, Есөнбулаг сумын ЗДТГ-125.5 сая төгрөг, Жаргалан сумын ЗДТГ-70.8 сая төгрөг, Алтай хотын тохижилт үйлчилгээний газар ААТҮГ-59.5 сая төгрөг, Хөхморьт сумын ЗДТГ-35.2 сая төгрөг, Эрдэнэ сумын ЗДТГ-25.8 сая төгрөг, Тайшир сумын ЗДТГ-23.0 сая төгрөг, БОАЖГ-22.0 сая төгрөг, Ундарга-Алтай ААТҮГ-20.2 сая төгрөг, Төгрөг сумын ЗДТГ-19.0 сая төгрөг, Жаргалан сумын ИТХ-18.0 сая төгрөг, Бугат сумын ЗДТГ-14.9 сая төгрөг, Халиун сумын ЗДТГ-13.9 сая төгрөг, Чандмань сумын ЗДТГ-11.6 сая төгрөг, Эрдэнэ сумын ИТХ-10.9 сая төгрөг/;
- Тендерт шалгараагүй ААН байгууллагаас худалдан авалт хийсэн 229.4 сая төгрөг /Солонго Дулааны станц ААТҮГ/;
- Цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй нийт 66.1 сая төгрөг /Бигэр сумын ЗДТГ-19.0 сая төгрөг, Бигэр сумын ИТХ-15.0 сая төгрөг, Тайшир сумын ЗДТГ-14.5 сая төгрөг, Нийтлэг үйлчилгээ УТҮГ-9.1 сая төгрөг, Жаргалан сумын ЗДТГ-4.7 сая төгрөг, Алтай сумын-ЗДТГ 3.8 сая төгрөг/;
- Хамаарал бүхий этгээдийн данс руу мөнгө шилжүүлж, худалдан авалт хийсэн 62.9 сая төгрөг /Марал-Алтай ӨЭМТ-48.6 сая төгрөг, Есөнбулаг сумын ЗДТГ-14.3 сая төгрөг, Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ/;
- Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газар УТҮГ нь ашиглалтын гэрээ байгуулж, түрээсийн орлогыг төвлөрүүлээгүй;
- Жолоодох эрхээ хасуулсан ажилтан жолоочийн үүргээ гүйцэтгэсэн /Марал-Алтай ӨЭМТ/;
- Ажиллагсдын нэр дээр авсан урьдчилгааг хамаарал бүхий этгээдийн дансаар шилжүүлэн авсан /Марал-Алтай ӨЭМТ/;
- Ажилтнаас хууль, журамд заагаагүй 6.4 сая төгрөгийг суутгасан /Есөнбулаг сумын ЗДТГ/;

- *Ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд ээлжийн амралтын дуусгалтын тооцоог хийгээгүй /Жаргалан сумын ЗДТГ, Марал-Алтай ӨЭМТ, аймгийн ЗДТГ/.*

ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 134 аж ахуйн нэгж байгаа бөгөөд 19 аж ахуйн нэгжээс сумдад 204.1 сая төгрөгийг хандивыг данс бүртгэлд тусгаагүй зарцуулсан.

IV БҮЛЭГ. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт төсвийн дансаар 3,463.4 сая төгрөг төвлөрсөн нь өмнөх оноос 34.6 буюу 890.7 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Нийт орлогын 82.7 хувийг орон нутгийн төсвөөс, 17.3 хувийг бусад эх үүсвэрээс бүрдүүлжээ.

Нэмэлт төсвийн санхүүжилтийн эх үүсвэр дараах орлогоос бүрджээ.

- Дээд шатны төсөв захирагчдаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө-2,071.4 сая төгрөг;
- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж-154.9 сая төгрөг;
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого-445.7 сая төгрөг;
- ЗГНХ, ЗДНХ болон түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 791.4 сая төгрөг байна.

Төсвийн байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 3,463.4 сая төгрөгийг дамжуулан зарцуулсан нь төсвийн хяналтыг сулруулах эрсдэлтэй байна. Тухайлбал: Орон нутгийн төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө тасарсан боловч нэмэлт орлогын дансаар 2023 онд 445.6 сая төгрөг төвлөрч зарцуулсан.

Нэмэлт орлогыг дараах зардлуудад зарцуулсан байна. Үүнд:

- Нэмэлт төсвийг зарцуулахдаа цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 41.1 сая төгрөг;
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 16.3 сая төгрөг;
- Хангамж бараа материалын зардалд 132.9 сая төгрөг;
- Норматив зардалд 1.0 сая төгрөг;
- Эд хогшил, урсгал засварын зардал 73.1 сая төгрөг;
- Томилолтын зардалд 10.5 сая төгрөг;
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 1,436.6 сая төгрөг;
- Бараа үйлчилгээний бусад зардалд 1,024.1 сая төгрөг;
- Хөрөнгийн зардалд 23.7 сая төгрөг;
- Тэтгэмж шагнал урамшууллын зардалд 5.8 сая төгрөгийг зарцуулж, улс, орон нутгийн төсөвт 698.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилт өмнөх оноос 30.0 хувь буюу 1,111.8 сая төгрөгөөр өсөж, төсвийн гүйцэтгэлийн 7.2 хувийг эзэлж байна. Нэмэлт төсвийн санхүүжилт жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь төсвийн зардал тэлэх, хяналтгүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлж байна.

Илрүүлэлт

- *Нэмэлт санхүүжилтийн дансаар 49.4 сая төгрөгийн тохижилтын ажлын тоо хэмжээ, ажлын даалгаваргүй ажил гүйцэтгүүлсэн /Есөнбулаг сумын ЗДТГ/.*

V БҮЛЭГ. ТӨСВИЙН ТӨСӨЛД ӨГСӨН САНАЛ, ДҮГНЭЛТ

Төрийн аудитын байгууллага нь тооцоо, судалгаандаа үндэслэн 2023 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх төрлийн 870.8 сая төгрөгийн, төсвийн зардал бууруулах 50.6 сая төгрөгийн, үр ашиг нэмэгдүүлэх 6 санал өгсөн.

Хүснэгт 9. Төсвийн санал, хэрэгжилт

Төсвийн санал			/сая.төгрөг/ Саналын хэрэгжилт		
Үзүүлэлт	Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Хувь
Зардал бууруулах	3	50.6	1	22.1	43.6
Орлого нэмэх	7	870.8	6	394.9	45.3
Үр ашиг	6	-	5	-	83.3
Дүн	16	921.4	12	417.0	57.4

Эх сурвалж: 2023 оны төсвийн төсөлд хийсэн аудитын тайлан

Төсвийн төсөлд өгсөн саналын биелэлт:

- Орлого нэмэгдүүлэх саналаас ус рашаан ашигласны төлбөрийн орлого, галт зэвсгийн албан татвар, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого, түрээсийн орлого, үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогуудаас 394.9 сая төгрөгийн орлого төвлөрч, өгсөн саналыг 45.3 хувьтай хэрэгжүүлсэн.
- Зардал бууруулах 50.6 сая төгрөгийн 3 саналаас 22.1 сая төгрөгийн 1 зардлыг бууруулж, саналын биелэлт 43.6 хувьтай байна.
- Үр ашиг нэмэгдүүлэх 6 саналаас 5 саналыг авч, хэрэгжилт 83.3 хувьтай байна.

Аймгийн 2023 оны төсвийн санхүүгийн нийт эх үүсвэр 55,614.1 сая төгрөг, нийт зарлага 56,181.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс 567.5 сая төгрөгийн зарцуулж, 567.5 сая төгрөгийн алдагдалтай гарчээ.

Хүснэгт 10. Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /+хэмнэлт, -хэтрэлт/	Хувь
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	63,492.9	56,181.5	7,311.4	88
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	63,492.9	55,614.1	7,878.8	88
	Төсвийн тэнцэл		(567.5)		

VI АУДИТЫН ДҮГНЭЛТ

Говь-Алтай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар нийт 2,725.8 сая төгрөгийн 5 зөрчил³ илэрснээс, 167.8 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 2,558.0 сая төгрөгийн 3 зөвлөмж, Үндэсний аудитын газрын Санхүү, нийцлийн аудитын газарт 1 санал хүргүүлсэн.

Аймгийн 2023 оны төсвийн санхүүгийн эх үүсвэрийн дүн 55,614.1 сая төгрөг, нийт зарлагын дүн 56,181.5 сая төгрөгийн гүйцэтгэлтэй болохыг аудитаар баталгаажууллаа.

Аймгийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлангийн дүнд үндэслэн дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллах, төсвийн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэх шаардлагатай байна.
2. Орон нутгийн нийт орлого 828.6 сая төгрөгөөр давж биелсэн боловч аймаг, Бигэр, Дарив, Халиун, Хөхморьт, Цээл, Шарга сумдын орлого 473.7 сая төгрөгөөр тасарсан байна.
3. Аймгийн төрийн сангаас 19 сум, байгууллагад 2,353.9 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. Удирдлагын буруутай шийдвэрээр ажлаас халагдсан ажилтнуудад 109.1 сая төгрөгийн цалингийн нөхөн олговрыг олгож, буруутай этгээдээс нэхэмжлээгүй байгууллагын төсөв хохироосон байна
5. Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй 134 аж ахуйн нэгж байгаа бөгөөд 19 аж ахуйн нэгжээс сумдад 204.1 сая төгрөгийн хандивыг данс бүртгэлд тусгаагүй зарцуулсан.
6. Хантайшир Уулын аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн арга хэмжээнд төсвөөс 593.6 сая төгрөгийг зарцуулсан нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан хязгаараас 58.7 сая төгрөгөөр илүү, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.
7. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээг батлахдаа хөрөнгө оруулалтын зардалд 23.5 хувийг, хөтөлбөр арга хэмжээний зардалд 74.1 хувийг зарцуулахаар шийдвэрлэсэн байна.

6.1 ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхдээ баталсан нөөц хөрөнгийн 80.0-90.0 хувийг нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг, уралдаан тэмцээний шагнал урамшуулал зэргээр үр ашиггүй зарцуулж байгаа тул журмын 2.1.4, 2.1.5, 2.1.6 дугаар заалтыг өөрчлөх, тодорхой болгох саналыг Сангийн яаманд хүргүүлэхийг уламжилж байна.

6.2 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын даргад:

1. Орон нутгийн орлогын төлөвлөгөөг үндэслэл болгосон тооцоо судалгааг нарийвчлан тооцон, хянаж батлах.
2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээг батлахдаа “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д нийцүүлэн буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал олгох хөтөлбөр, арга хэмжээг тусгахгүй байх.

Аймгийн Засаг даргад:

1. Батлагдсан төсвийн хуваарийн дагуу санхүүжилтийг тухай бүр олгож, шат шатны төрийн сангийн хяналтыг сайжруулах.
2. Орон нутгийн орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй, тооцоо судалгаатай боловсруулж батлуулах.
3. Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшиж буй аж ахуйн нэгж байгууллагуудтай гэрээ байгуулж, ил тод болгон, хяналт тавьж ажиллах.
4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийг дэмжих, хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл арга хэмжээг тусган батлуулах.

